



НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2015-01-29

Улаанбаатар хот

Дугаар 23/01

Авлигын эсрэг нийслэлийн хөтөлбөр, стратеги төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1.1 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2015 оны 01/108 дугаар албан бичгээр өргөн мэдүүлсэн саналыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. "Авлигын эсрэг нийслэлийн хөтөлбөр"-ийг нэгдүгээр, "Хөтөлбөрийн хүрээнд 2015-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө"-г хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Авлигын эсрэг нийслэлийн хөтөлбөр, үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг нийслэлийн төсөвт жил бүр тусгаж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /Э.Бат-Үүл/-д даалгасугай.

ДАРГА

Д.БАТТУЛГА

Хавсралт АВЛИГЫН ЭСРЭГ НИЙСЛЭЛИЙН ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Авлига нь улс орнуудын нийгэм, эдийн засгийн хурдацтай хөгжилд саад тотгор учруулж, ардчилал, шинэчлэлийн явцыг сааруулах хүчин зүйл болдгийг дэлхийн улс орнууд хүлээн зөвшөөрч, авлигатай тэмцэх санаачилга гарган тодорхой ажлуудыг хийж байна.

Олон улсын Авлигын ил тод байдлын ойлголтын талаарх 2013 онд хийгдсэн судалгаагаар Монгол Улсын иргэн авлигыг нийгэмд буй хамгийн ноцтой асуудлаар тооцсон хэвээр байхад судалгаанд оролцогчдын 86 хувь нь төрийн байгууллагад бугшсан авлигыг "сэтгэл эмзэглүүлсэн асуудал" хэмээн тооцож, 77 хувь нь төрийн албан хаагчид, төрийн албаны ажилтнуудыг авлигад автсан буюу хэт автсан хэмээн тодорхойлжээ.

Төрөөс авлигын эсрэг баримталж буй бодлого, хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоог хангах, нийслэлээс баримтлах авлигын эсрэг нэгдсэн бодлогыг тодорхойлох, авлигын эсрэг хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн үйлчилгээг хүнд сурталгүй, чирэгдэлгүй хүргэх, сайн засаглалыг бэхжүүлэх, Монгол Улсын Ерөнхийлөгчийн "Том төрөөс Ухаалаг төр рүү" санаачилга, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн авлигын талаарх зөвлөмжийг хэрэгжүүлэх, шударга, хариуцлагатай ил тод нээлттэй Улаанбаатар хот болох зорилтыг үндэслэн энэхүү хөтөлбөрийг боловсруулав.

"Нээлттэй Улаанбаатар-2014" Авлигын эсрэг форумаас авлигатай тэмцэх шат дараатай ажлыг зарлан тунхагласны дагуу Авлигын эсрэг нийслэлийн хөтөлбөр, үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө боловсруулан батлуулж хэрэгжүүлэх, холбогдох ажлыг эрчимжүүлэх, ил тод, нээлттэй Улаанбаатар хотыг бий болгох зорилгыг тавьсан.

Авлигын эсрэг нийслэлийн хөтөлбөр, үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөг "Найрсаг Улаанбаатар", "Ухаалаг Улаанбаатар", "Орон сууцны хөтөлбөр", "Нийслэлийн нутгийн захиргааны удирдлагын бүтцийг боловсронгуй болгох хөтөлбөр"-үүдтэй уялдуулан хэрэгжүүлнэ.

Хавсралт

1.1. Хөтөлбөр боловсруулах үндэслэл, хэрэгцээ, шаардлага

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Авлигын эсрэг конвенцид Монгол Улс 2005 онд нэгдэн орсон. Авлигын эсрэг хуулийг 2006 онд, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг 2011 онд, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг 2012 онд баталсан.

Эдгээр хуулиас гадна Шилэн дансны тухай хуулийг 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн нь нийтийн албыг авлигаас ангид, хариуцлагатай, ил тод болгох нэг чухал нөхцөл боллоо.

Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт "Авлига, хүнд сурталтай хийх тэмцэлд эрс шинэчлэл гаргах"-аар зорилго болгосон. Мөн Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт засаглалыг сайжруулах, авлигын эсрэг үйл ажиллагааг тусгайлан хэрэгжүүлэх "Авлигагүй Улаанбаатар" гэсэн тусгай бүлэг асуудлыг тусгасан.

2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар Монгол Улсын нийт иргэдийн 46.8 хувь буюу 1 сая 372 мянган хүн нийслэлд оршин суудаг, улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагын 71.9 хувь нь нийслэлд үйл ажиллагаагаа явуулж байна. Иймд нийслэл нь Монгол Улс дахь авлигын эсрэг асуудалд шийдвэрлэгч үүрэг гүйцэтгэж, манлайлан оролцох шаардлагатай байна.

1.2. Нийслэл дэх авлигын эсрэг үйл ажиллагааны өнөөгийн байдал

Хотын үйл ажиллагааг ил тод байлган, гүйцэтгэлд нь хяналт тавих эрхийг иргэдэд олгохын зэрэгцээ хотын тулгамдаж буй асуудлаар иргэдийн дунд олон нийтийн санал асуулга явуулж, тэдний саналд үндэслэн шийдвэр гаргадаг болно гэсэн зорилтын хүрээнд дүүргүүдэд нийт 78 иргэний танхимыг байгуулж, 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар давхардсан тоогоор 249 удаа 72,5 мянган иргэн, нийслэлийн 310 мянган өрх оролцсон байна.

Төрийн үйлчилгээг хөнгөвчлөх, иргэдэд ил тод нээлттэй болгох зорилгоор нийслэлээс үзүүлж буй үйлчилгээний судалгаа хийж, 540 төрлийн үйлчилгээний жагсаалтыг гаргаад байна.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Бүгд Найрамдахчуудын олон улсын хүрээлэнтэй хамтран Авлигатай тэмцэх газар, Азийн Ардчиллын сүлжээ, Тайванийн Ардчиллын сан, Нийтлэг эрх ашгийн төв, Трансперэнси Интернэшнл, Ардчиллын төлөөх дэлхийн хөдөлгөөн, Үндэсний Ардчиллын сан, Олон улсын хувийн жижиг, дунд үйлдвэрлэлийн төв зэрэг байгууллагын оролцоотой "Нээлттэй Улаанбаатар-2014" Авлигын эсрэг форумыг 2014 оны 10 дугаар сард Улаанбаатар хотод амжилттай зохион байгуулсан.

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас иргэдэд үзүүлж байгаа төрийн үйлчилгээ болон нийслэлийг хөгжүүлэх чиглэлээр гарч байгаа шийдвэрт иргэдийн санал бодлыг тусгах, иргэдийн эрэлт, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх зорилгоор "Иргэд хүлээн авах төв"-ийг байгуулж, өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авахаас гадна "1800-1200" тусгай дугаар бүхий лавлах утасны үйлчилгээгээр иргэдэд нээлттэй мэдээлэл, лавлагаа өгч байна. Мөн нийслэлийн иргэдээсээ SMS /мессеж/-ээр санал асуулга, судалгаа авч нэгтгэн бодлого, үйл ажиллагаандаа тусган ажиллаж байна. Түүнчлэн Авлигын эсрэг Олон нийтийн зөвлөл 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан.

Хоёр. Хөтөлбөрийн зарчим, зорилго, зорилтууд

2.1. Хөтөлбөрийн зарчим

"Авлигын эсрэг нийслэлийн хөтөлбөр"-т тусгагдсан арга хэмжээнүүд дараах зарчимд тулгуурлана:

2.1.1. Хууль дээдлэх: Хүн бүр хууль, шүүхийн өмнө тэгш эрхтэй. Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль болон авлигатай холбоотой аливаа шийдвэрүүдийг хэлбэрэлтгүй сахин биелүүлдэг байх;

2.1.2. Хариуцлагатай байх: Сонгогдсон буюу томилогдсон эсэхээс үл хамааран албан тушаалтан олон нийтийн өмнө хуулийн, улс төрийн, эдийн засгийн болон ёс зүйн хариуцлага хүлээдэг байх;

2.1.3. Ил тод, нээлттэй байх: Хуульд зааснаас бусад тохиолдолд иргэдийн мэдээлэл авах эрхийг хязгаарлахгүй, төрийн эрх бүхий байгууллага, хувь хүн, хуулийн этгээд аливаа мэдээллийг саадгүй олж авах нөхцөл, боломжийг бүрдүүлэх арга хэмжээ авах;

Хавсралт

2.1.4. Нийтийн ашиг сонирхлыг хамгаалах: Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ нийтийн ашиг сонирхлыг бусад ашиг сонирхлоос дээгүүр тавьж, албан тушаалаа өөрийн болон хамаарал бүхий этгээдийн ашиг олох хэрэгсэл болгохгүй байх;

2.1.5. Хамтын ажиллагаа уялдаа холбоотой байх: Авлигын эсрэг үйл ажиллагаанд оролцогч бүх байгууллага нягт хамтран ажиллаж, хүрэх зорилтууд, хэрэгжүүлэх арга хэмжээг нэг мөр тодорхойлж, ажлын уялдаа холбоог бэхжүүлсэн байх;

2.1.6. Олон нийтийн хүч, оролцоонд түшиглэх: Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийт, иргэний нийгэм, хувийн хэвшлийн оролцоо чухал болохыг харилцан хүлээн зөвшөөрөх.

2.2. Хөтөлбөрийн зорилго, зорилтууд

Нийслэлийн нутгийн өөрөө удирдах ёсны болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтан, иргэд, олон нийтийг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, авлигын эсрэг хандлага, үзэл санааг төлөвшүүлэх, ил тод, нээлттэй, бүтээмжтэй, хариуцлагатай, иргэний нийгмийн оролцоог хангасан нийслэлийг хөгжүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгодоо хүрэхийн тулд нийслэлийн нутгийн өөрөө удирдах ёсны болон нутгийн захиргааны байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн оролцоотойгоор авлигын эсрэг авч хэрэгжүүлэх дараах 7 зорилтыг дэвшүүлж байна. Үүнд:

Авлигагүй нийтийн алба

Ил тод, шударга, хариуцлагатай, ёс зүйтэй, авлигагүй, нийслэлийн нутгийн өөрөө удирдах ёсны болон нутгийн захиргааны байгууллагын нийтийн албыг бэхжүүлэх;

Авлигаас ангид төрийн албан хаагч

Нийтийн албыг улс төр, эдийн засаг, хувийн ашиг сонирхлын нөлөөллөөс ангид байлгаж, мэргэшсэн албан хаагч болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын ажилтнуудын баталгааг хангаж, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх;

Тунгалаг санхүүтэй Улаанбаатар

Нийслэл, дүүргийн нутгийн захиргааны байгууллага, өмчит үйлдвэрийн газар, компаниудын төсвийн зарцуулалт, худалдан авах ажиллагаа болон зөвшөөрөл олголтыг олон нийтэд ил тод нээлттэй, хяналттай болгох;

Нийслэлийн өмчийн ил тод, үр ашигтай тогтолцоо

Нийслэлийн өмчийг удирдлага, бүртгэл, хяналт, үнэлгээний нэгдсэн, ил тод тогтолцоотой болгох, хөрөнгийн үр ашгийг нэмэгдүүлэх, зарим өмчийг хувьчлах, төрийн аж ахуйн үйл ажиллагааг хязгаарлах;

Дүрэмтэй хот

Хотын амьдралын олон талт асуудлыг зохицуулсан "Дүрэмтэй хот" хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

Авлигыг үл тэвчигч хотын иргэд

Авлигын эсрэг ил тод Улаанбаатар академийг байгуулж, иргэд, олон нийтийн авлигын эсрэг боловсролыг нэмэгдүүлж, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өргөнөөр зохион байгуулах;

Иргэн, иргэний нийгмийн оролцоо

Нийслэлийн бүх шатны байгууллагын нийтийн эрх ашгийг хөндсөн аливаа асуудлаар шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэд, иргэний нийгмийн оролцоог хангах, авлигын болон эрсдлийн хөндлөнгийн үнэлгээ хийдэг тогтолцоонд шилжих;

2.3. Үйл ажиллагааны

Зорилт 1. Ил тод, шударга, хариуцлагатай, ёс зүйтэй, авлигагүй, нийслэлийн нутгийн

Хавсралт

өөрөө удирдах ёсны болон нутгийн захиргааны байгууллагын нийтийн албыг бэхжүүлэх

1. Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүрэн хангах, зохион байгуулалтын шинэлэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

1. Нийслэлээс үзүүлдэг төрийн үйлчилгээг цахим нэг цонхны хэлбэрээр иргэдэд хүргэх, үйлчилгээний хурд, хүртээмжийг сайжруулах;

1. Нийслэлийн нутгийн захиргааны бүх шатны байгууллагыг судалгаанд суурилж, үйлчилгээнд тулгуурласан иргэн төвтэй нээлттэй болгох, төрийн үйлчилгээ болон Улаанбаатар хотын талаарх мэдээллийг шуурхай, хялбар авах боломжийг нэмэгдүүлэх;

1. Төрийн бус байгууллагаас санаачилсан авлигын эсрэг ил тод байдлын түншлэлд нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд нэгдэх, хамтран ажиллах;

1. Авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, нийтэд мэдээлэх дотоод хяналтын механизмыг бүрдүүлэх;

1. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын цахим хуудасны ашиглалтыг сайжруулах, заавал байх мэдээллийн агуулгыг тогтоох, мэдээлэл түгээх бүхий л арга хэрэгслийг бүрэн ашиглах, байнга шинэчлэх, хайлт хийхэд хялбар болгох, www.ulaanbaatar.mn цахим хуудасны мэдээллийг төрөлжүүлэх;

1. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага хоорондын уялдаа холбоог сайжруулж, үйл ажиллагаа болон мэдээллийн давхцалыг арилгах;

1. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагаас үзүүлж буй төрийн үйлчилгээний ил тод, нээлттэй байдалд хөндлөнгийн үнэлгээ, мониторинг хийх төсөл /Check my service/-ийг хэрэгжүүлж, хариуцлагын тогтолцоог бий болгох;

1. Нийслэлээс иргэн, хуулийн этгээдэд үзүүлж байгаа төрийн үйлчилгээг нэг дор, цогцоор нь, харьяалал харгалзахгүйгээр хүргэх, төрийн үйлчилгээний төвүүдийг нийслэл, дүүрэгт, төрийн үйлчилгээний танхимыг хороодод байгуулж, үйлчилгээний стандарт багцыг бүрдүүлэх;

1. Төрийн үйлчилгээний нэгдсэн мэдээллийн систем /платформ/-ыг хөгжүүлэх, цахим үйлчилгээг нэвтрүүлэх;

Зорилт 2. Нийтийн албыг улс төр, эдийн засаг, хувийн ашиг сонирхлын нөлөөллөөс ангид байлгаж, мэргэшсэн албан хаагч болон орон нутгийн өмчит

үйлдвэрийн газрын ажилтнуудын баталгааг хангаж, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх

Хавсралт

1. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагад улс төрийн томилгоог зогсоох, улс төр эдийн засаг, хувийн ашиг сонирхлын нөлөөллийг бууруулах, мэргэшсэн албан хаагчдаар нийтийн албыг бэхжүүлэх;

1. Албан хаагчийн эрх зүйн болон нийгмийн баталгааг хангаж, тогтвортой ажиллуулах нөхцөлийг бүрдүүлэх;

1. Албан хаагчийн ажлын бүтээмжид чиглэсэн гүйцэтгэлийн хяналтын горимд шилжүүлэх, ажлын үр дүнгээр урамшуулах журмыг шинэчлэн мөрдүүлэх;

1. Албан хаагчийн сэтгэлгээ хандлагыг өөрчлөх, мэргэшүүлэх;

1. Ажлын байран дахь ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдлийг бууруулах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх;

Зорилт 3. дүүргийн нутгийн захиргааны байгууллага, өмчит үйлдвэрийн газар, компаниудын төсвийн зарцуулалт, худалдан авах ажиллагаа болон зөвшөөрөл олголтыг олон нийтэд ил тод нээлттэй, хяналттай болгох

1. Төсвийн орлого, зарлага болон өр, зээл, өмч, хөрөнгийн зарцуулалттай холбоотой аливаа мэдээллийг олон нийтэд ил тод, нээлттэй, хяналттай болгох, нийслэл, дүүргийн нутгийн захиргааны байгууллага, өмчит үйлдвэрийн газар, компаниудыг "Шилэн данс"-ны тогтолцоонд шилжүүлэх

1. Төсвийн төлөвлөлтийн үр ашигтай байдал, гүйцэтгэлийн хэмнэлт, зарцуулалт дахь хөндлөнгийн хяналт, оролцоог нэмэгдүүлж, дотоод аудитын хяналтыг боловсронгуй болгох;

1. Хувийн хэвшлийн байгууллагын хөрөнгө оруулалтаар гүйцэтгэх боломжтой ажил үйлчилгээг төрийн байгууллага хэрэгжүүлэхийг хязгаарлах;

1. Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох журмыг хялбарчлах ³Шилэн лиценз' системийг ашиглах;

1. Нутгийн захиргааны байгууллагуудын худалдан авах ажиллагааг зөвхөн тухайн салбарт мэргэшсэн мэргэжлийн байгууллага зохион байгуулах механизмыг бүрдүүлэх, цахим хэлбэрт оруулж ³Шилэн тендер'-ийн тогтолцоонд шилжүүлэх;

1. Худалдан авах ажиллагаан дахь нууцлалыг сайжруулах, хариуцлагыг өндөржүүлэх, хар жагсаалтад байгаа хуулийн этгээдийн цахим сонгон шалгаруулалтад оролцох боломжийг хязгаарлах;

1. Худалдан авах үйл ажиллагааг ³Видео тендер' болон бусад хэлбэрээр зохион байгуулж, тендерийн ил тод байдлыг сурталчлах;

Хавсралт

1. Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын үйл ажиллагааг төслийн менежментийн зарчимд шилжүүлж, удирдлага, санхүүгийн үйл ажиллагааг ил тод болгох;

1. Нийслэл, дүүргийн сонгуулийн хороод, нам, эвслийн сонгуулийн зардлын тайланг нийтэд мэдээлэх;

Зорилт 4. Нийслэлийн өмчийг удирдлага, бүртгэл, хяналт, үнэлгээний нэгдсэн, ил тод тогтолцоотой болгох, хөрөнгийн үр ашгийг нэмэгдүүлэх, зарим өмчийг хувьчлах, төрийн аж ахуйн үйл ажиллагааг хязгаарлах;

1. Нийслэлийн өмчийн бүртгэл хяналт, үнэлгээний нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх, үйл ажиллагааны үр дүнг тооцох механизмыг сайжруулж, хариуцлагыг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг ил тод болгох;

1. Нийслэлийн өмчит үйлдвэрийн газар нэмж байгуулахыг хязгаарлах;

1. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын чиг үүргийг төрөлжүүлж, бүтэц зохион байгуулалтыг оновчтой болгох;

1. Нийслэлд зайлшгүй шаардлагатай байгаагаас бусад нийслэлийн өмчит үйлдвэрийн газар, нийслэлийн өмчийг хувьчлах;

1. Газрын бирж байгуулах, газрын мэдээллийн нэгдсэн сантай болох;

Зорилт 5. Хотын амьдралын олон талт асуудлыг зохицуулсан ³Дүрэмтэй хот хөтөлбөрийг хэрэгжүүлэх

1. Нийслэл дэх хотуудыг иргэддээ нээлттэй байх, иргэдийн оролцоотой асуудлаа шийддэг байхад чиглэсэн дүрэмтэй болгох, хотын Үндсэн дүрмийг хотын оршин суугчдын санал асуулгаар батлах;

1. Хотын удирдлага, хотод оршин суугч бүр нэг л дүрэм журмын хүрээнд харилцах нөхцөлийг бүрдүүлж, хотын амьдралын асуудлаар гарах аливаа шийдвэр зөвхөн олонхийн эрх ашигт нийцэж байх тогтолцоог бий болгох;

Зорилт 6. Авлигын эсрэг ил тод Улаанбаатар академийг байгуулж, иргэд, олон нийтийн авлигын талаарх боловсролыг нэмэгдүүлж, соён гэгээрүүлэх ажлыг өргөнөөр зохион байгуулах

1. Авлигын талаар нийслэлийн иргэдэд мэдээлэл өгч, соён гэгээрүүлж, тэдний оролцоог хангах тогтвортой институци болох ³Авлигын эсрэг ил тод Улаанбаатар академи"-ийг байгуулах, бүс нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулах;

1. Олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх, авлигын эсрэг туршлагаас судлах, шинжээчдийг урьж ажиллуулах, тэдгээрийн зөвлөмжийг хэрэгжүүлэх;

Хавсралт

1. Авлигыг үл тэвчих ухамсрыг иргэдэд төлөвшүүлэх нөхцлийг бүрдүүлэх бүхий л үйл ажиллагааг дэмжих;

1. Авлига, хууль бус үйлдлийн талаар мэдээлсэн албан тушаалтан, иргэнийг урамшуулах, шүгэлдэгчийн эрхийг хамгаалахтай холбоотой эрх зүйн орчинг бүрдүүлэхэд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах;

Зорилт 7. Нийслэлийн бүх шатны байгууллагын нийтийн эрх ашгийг хөндсөн аливаа асуудлаар шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэд, иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангах, авлигын болон эрсдлийн хөндлөнгийн үнэлгээ хийдэг тогтолцоонд шилжих

1. Нийслэлийн бүх шатны байгууллага нийтээр дагаж мөрдөх, нийтийн эрх ашгийг хөндсөн шийдвэр гаргах, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, үнэлэхэд иргэд, иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангах;

1. Нийслэлийн бүх шатны байгууллага ³Нийтийн зар мэдээ'-г хүргэдэг болох;

1. ³Иргэдийн санаачилгын хороо'-г хөхиүлэн дэмжих;

Гурав. Хөтөлбөрийн хугацаа, үе шат, хүрэх үр дүн

Хөтөлбөрийг 6 жилийн хугацаатай 2 үе шаттай хэрэгжүүлнэ:

1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх I үе шат /2015-2016/

Хүрэх үр дүн:

1. ³Авлигын эсрэг ил тод Улаанбаатар академи" байгуулсан байна.

1. Хотын багц дүрэмтэй болсон байна.

1. Ажлын байран дахь ашиг сонирхлын зөрчил болон зүй бус нөлөөлөл үүсэх эрсдлийг бууруулах арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлсэн байна.

1. Цахим үйлчилгээний дэд бүтэц бий болж, төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх тодорхой алхам хийгдсэн байна.

1. Нийслэл, дүүргийн нутгийн захиргааны байгууллага, өмчит үйлдвэрийн газар, компаниудын санхүүг шилэн данс, шилэн тендер, шилэн лицензийн тогтолцоонд шилжүүлж, нийтийн ажил гүйцэтгэгч компаниудын болон төсвийн зарцуулалтыг олон нийтэд ил тод, нээлттэй, хяналттай болгосон байна.

Хавсралт

1. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага дахь авлигын эрсдэл буурч, нийслэлийн болон иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагаа сайжирсан байна.

1. Авлигын эсрэг, эрсдэлийн хөндлөнгийн үнэлгээ, мониторинг хийдэг тогтолцоог нэвтрүүлж эхэлсэн байна.

1. Олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх, авлигын эсрэг туршлагаас судлах шинжээчдийг урьж ажиллуулах, тэдгээрийн зөвлөмжийг хэрэгжүүлж эхэлсэн байна.

1. II үе шат /2017-2020/

Хүрэх үр дүн:

1. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагад улс төрийн томилгоог зогсоох, улс төр эдийн засаг, хувийн ашиг сонирхлын нөлөөллийг бууруулах, мэргэшсэн албан хаагчдаар нийтийн албыг бэхжүүлсэн байна.

1. Төрийн бус байгууллага, олон улсын байгууллагаас гаргадаг судалгаагаар Авлигын индексийн үзүүлэлт сайжирч, шударга байдлын түвшин дээшилсэн байна.

1. Төрийн үйлчилгээний ил тод, нээлттэй байдал хангагдсан байна.

1. Олон нийтийн оролцоо, хяналт бэхжсэн байна.

1. Нийслэлийн өмчийн хөрөнгийн үр ашгийг нэмэгдүүлэх цогц арга хэмжээг авах, зарим өмчийг хувьчлах, төрийн аж ахуйн үйл ажиллагааг хязгаарлан оролцоог багасгасан байна.

1. Албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүй, сахилга баттай холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх, нийтэд мэдээлэх арга хэлбэрийг нарийвчилж, хариуцлагаас зайлсхийх, гаргасан зөрчилд тохироогүй хариуцлага хүлээлгэх боломжийг хязгаарлаж, дотоод хяналтын механизмыг бүрдүүлсэн байна.

Дөрөв. Хөтөлбөрийн санхүүжилт

1. Хөтөлбөрийн санхүүжилт дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

1. Улс болон нийслэлийн төсөв;

1. Олон улсын байгууллага болон төрийн бус байгууллагын төслийн хөрөнгө;

Хавсралт

1. Бусад эх үүсвэр;

4.2. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг жил бүр Нийслэлийн төсөвт тусгаж батлуулна

Тав. Хөтөлбөрийн хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээ түүний зохион байгуулалт

1. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

1. Хөтөлбөрт заасан чиг үүргийг нийслэлийн нутгийн өөрөө удирдах ёсны болон нутгийн захиргааны байгууллага, орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, компани, орон нутгийн төсвөөс санхүүжилт авсан аж ахуйн нэгж, байгууллага хэрэгжүүлнэ.

1. Нийслэлийн Засаг даргын дэргэд хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх салбаруудын төлөөлөл бүхий орон тооны бус хороо ажиллах бөгөөд уг хороог Нийслэлийн Засаг дарга ахална.

1. Нийслэлийн Засаг дарга нь Хорооны дүрмийг баталж, гишүүдийг томилно.

1. Хорооны Ажлын албаны чиг үүргийг нийслэлийн Засаг даргын Тамгын газар гүйцэтгэх бөгөөд уг алба нь хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, нийслэлд хэрэгжиж буй бусад төсөл, хөтөлбөр, хэрэгжүүлэгч байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, бүс нутгийн болон олон улсын байгууллагуудтай хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр хамтын ажиллагааг хөгжүүлнэ.

1. Хороо нь энэхүү хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлт, аргачлалыг баталж, мөрдүүлэхээс гадна санал зөвлөмж өгөх, хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар Хорооны гишүүдийг тогтмол мэдээллээр хангах, иргэд, олон нийтэд хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар мэдээлэл хүргэх, хэрэгжилтийн байдлыг үнэлэх, хяналт тавьж ажиллана.

1. Нийслэлийн Дотоод аудитын алба нь нийслэлийн нутгийн захиргааны болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, орон нутгийн өмчийн оролцоотой компани, нийслэлээс санхүүжилт авсан бүх байгууллагын санхүү, хөрөнгөтэй холбоотой үйл ажиллагаанд шууд хяналт тавьж ажиллана.

1. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь хөтөлбөрийн жил бүрийн тайланг үр дүнгийн үнэлгээний хамт хэлэлцэж санал, дүгнэлт гаргана. Гаргасан санал, дүгнэлтийн мөрөөр авсан арга хэмжээ, зохион байгуулсан үйл ажиллагаа, тэдгээрийн үр дүнтэй Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал танилцаж, холбогдох чиглэл өгнө.

1. Нийслэлийн хөтөлбөрийг мэдээллийн нэгдсэн цахим санд байршуулна.

Зургаа. Хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнах

Хавсралт

6.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийн тайланг үр нөлөөний үнэлгээний хамт дор дурдсан хугацаанд холбогдох байгууллагад хүргүүлнэ:

1. Нутгийн захиргааны байгууллагууд жил бүрийн 10 дугаар сарын 01-ний дотор Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт;

1. Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх нэгдсэн тайлан, үнэлгээ, танилцуулгыг жил бүрийн 10 дугаар сарын 20-ны дотор Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлж санал, дүгнэлт гарган олон нийтэд мэдээлнэ.

Хавсралт "АВЛИГЫН ЭСРЭГ НИЙСЛЭЛИЙН ХӨТӨЛБӨР"-ИЙН ХҮРЭЭНД 2015-2020 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

№

Хөтөлбөрийн заалт

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Хариуцах байгууллага, хэлтэс

Хяналт тавих

ЗОРИЛТ НЭГ. АВЛИГАГҮЙ НИЙТИЙН АЛБА

Ил тод, шударга, хариуцлагатай, ёс зүйтэй, авлигагүй, нийслэлийн нутгийн өөрөө удирдах ёсны болон нутгийн захиргааны байгууллагын нийтийн албыг бэхжүүлэх;

1.

Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүрэн хангах, зохион байгуулалтын шинэлэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

1. . Нутгийн захиргааны байгууллагууд нь авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, зохион байгуулалтын шинэлэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх тухай байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж ажиллах

ННЗБ-ууд, НЗУХ, ХЭЗХ

НЗДТГ

1. . UNPAN-Дэлхийн улс орнуудын Төрийн байгууллагуудын дунд зохион байгуулдаг "НҮБ-ын Шилдэг төрийн үйлчилгээ" шалгаруулах арга хэмжээнд Нийслэлийн нутгийн захиргааны бүх шатны байгууллагаас нэр дэвшүүлж жил бүр оролцох

ННЗБ-ууд, НЗУХ

НЗДТГ

1.

Нийслэлээс үзүүлдэг төрийн үйлчилгээг цахим нэг цонхны хэлбэрээр иргэдэд хүргэх, үйлчилгээний хурд, хүртээмжийг сайжруулах;

1. Иргэд, аж ахуйн нэгжүүдүүдэд үзүүлж буй төрийн үйлчилгээг онлайн үйлчилгээнд үе шаттай шилжүүлэх

Хавсралт

НМТГ

НЗДТГ

1. Төрд бүртгэгдсэн иргэний мэдээллийг төрийн байгууллагууд хоорондоо цахим хэлбэрээр солилцох нөхцөлийг бүрдүүлэх программ хангамжийг боловсруулж нэвтрүүлэх

НМТГ

НЗДТГ

1. "Иргэний цахим нэг цонх" онлайн үйлчилгээг бий болгох програм хангамжийг боловсруулж туршиж нэвтрүүлэх, программ хангамжийг хөгжүүлэх үйл ажиллагааг нь олон нийтэд сурталчлан түгээх

НМТГ ИХАТ

НЗДТГ

1.

Нийслэлийн нутгийн захиргааны бүх шатны байгууллагыг судалгаанд суурилж, үйлчилгээнд тулгуурласан иргэн төвтэй нээлттэй болгох, төрийн үйлчилгээ болон Улаанбаатар хотын талаарх мэдээллийг шуурхай, хялбар авах боломжийг нэмэгдүүлэх;

1. Хувийн хэвшлийн менежментийн зарим тэргүүн туршлагыг судлах туршлага солилцох, үйлчилгээний хурд соёлыг нь төрийн үйлчилгээнд нэвтрүүлэх, албан хаагчдын үйлчилгээний стандартыг боловсруулж, үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ, урамшуулал, хариуцлагын шинэлэг тогтолцоог бий болгох, мөрдүүлэх

НЗДТГ, ИХАТ

НЗДТГ

1. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах ажлыг үе шаттай зохион байгуулах

ИХАТ

НЗДТГ

1. Нийслэлийн лавлагаа мэдээллийн төвөөс иргэдэд хүргэж байгаа лавлагаа, мэдээллийн чанарыг сайжруулж, мэдээллийг хурдан шуурхай, хялбар түгээх, тусгай дугаарын 1800-1200 /hotline/ утсыг сурталчлах, иргэдийн хандалтыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах

ИХАТ ХМОНХХ НМТГ

НЗДТГ

1. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Иргэд хүлээн авах төвийн үйл ажиллагааг өргөжүүлэх, иргэд хүлээн төвөөс үзүүлж буй үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх

НЗДТГ, ИХАТ

НЗДТГ

1. Нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон болон тулгамдсан асуудлаар шийдвэр гаргахдаа иргэд, олон нийтээс мессеж /SMS/ санал авах ажлыг тогтмол зохион байгуулах

ИХАТ

НЗДТГ

1. Үйлчилгээний 1:1 стандартыг бий болгох

ИХАТ

НЗДТГ

1.

Төрийн бус байгууллагаас санаачилсан авлигын эсрэг ил тод байдлын түншлэлд нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд нэгдэх, хамтран ажиллах;

1. Нийслэлийн Засаг даргын дэргэд хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх салбаруудын төлөөлөл бүхий орон тооны бус Хороо байгуулах

НЗУХ

Хавсралт

НЗДТГ

1. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын шийдвэрүүдийн ил тод, нээлттэй байдал, албан тушаалтны хариуцлага ба авлигын эрсдлийн үнэлгээг ИНБ-аар тогтмол хийлгэх

ННЗБ-ууд

НЗДТГ

1. Нийслэлээс хэрэгжүүлж байгаа иргэдийн эрх ашгийг хөндсөн томоохон бодлогын чанартай арга хэмжээнүүд дээр хөндлөнгийн үнэлгээг хийлгэх, төсөл хөтөлбөрүүдийг боловсруулах

ННЗБ-ууд

НЗДТГ

1. Мэдээлэл технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компани их дээд сургуулиудаас "Төрийн үйлчилгээг онлайн болгох" шилдэг 10 төсөл шалгаруулах ажил зохион байгуулах

НМТГ, ХШҮХ

НЗДТГ

1.

Авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, дотоод хяналтын механизмыг бүрдүүлэх;

1. . Авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, шийдвэрлэлтэд хяналт тавих механизмыг сайжруулах, эх үүсвэрийг нэмэгдүүлэх

ИХАТ НМТГ

НЗДТГ

1. . Нутгийн захиргааны байгууллагын "Ёс зүйн хороо"-ны шийдвэрийг тухай бүрт олон нийтэд мэдээлдэг байх.

НЗУХ, ХМОНХХ

НЗДТГ

1.

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын цахим хуудасны ашиглалтыг сайжруулах, заавал байх мэдээллийн агуулгыг тогтоох, мэдээлэл түгээх бүхий л арга хэрэгслийг бүрэн ашиглах, байнга шинэчлэх, хайлт хийхэд хялбар болгох, www.ulaanbaatar.mn цахим хуудасны мэдээллийг төрөлжүүлэх

1.6.1. Цахим хуудас ашиглалтын журам боловсруулах

НМТГ

НМТГ

1.6.2. Заавал байх мэдээллийн жагсаалт гаргах

ННЗБ-ууд

НМТГ

1.6.3. Хайлт хийх боломжийг нэмэгдүүлэх

ННЗБ-ууд

НМТГ

1.6.4. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын шийдвэр, мэдээллийн нэгдсэн сантай болгох, мэдээллийг 72 цагийн дотор байршуулж хэвшүүлэх

ХМОНХХ

НЗДТГ

1.6.5. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын шийдвэр, үйл ажиллагааны талаарх мэдээллийг биечлэн, цахим хуудсаар, мессеж, телевиз, радио, сонин, сэтгүүл, эмхтгэл, гарын авлага, тараах хуудас, мэдээллийн самбар гэх мэт мэдээлэл түгээх бүхий л арга хэрэгслийг бүрэн ашиглан иргэдэд мэдээллэх тогтолцоог сайжруулах

ННЗБ-ууд

НМТГ

1.6.6. www.ulaanbaatar.mn цахим хуудасны мэдээллийг төрөлжүүлэх, хэрэгцээт мэдээллийг богино хугацаанд олж авах боломжийг нэмэгдүүлэх

НМТГ

Хавсралт

НЗДТГ

1.

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага хоорондын уялдаа холбоог сайжруулж, үйл ажиллагаа болон мэдээллийн давхцалыг арилгах;

1.7.1. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын мэдээллийн нэгдсэн санг бий болгох, мэдээлэл солилцох, баяжилт хийх тогтолцоог бүрдүүлэх, мэдээллийн давхцалыг арилгах

НМТГ

НЗДТГ

1.7.2. "Нийслэл хотын өгөгдлийн сангийн менежмент, мэдээллийн технологийн хөгжлийн стратеги, мастер төлөвлөгөө" бодлогын баримт бичгийг боловсруулах

НМТГ

НЗДТГ

1.7.3. Төрийн үйлчилгээний давхардал, хийдлийг арилгах

ИХАТ

НЗДТГ

1.

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагаас үзүүлж буй төрийн үйлчилгээний ил тод, нээлттэй байдалд хөндлөнгийн үнэлгээ, мониторинг хийх төсөл /Check my service/-ийг хэрэгжүүлж, хариуцлагын тогтолцоог бий болгох;

1.8.1. Төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллагаар үнэлгээ хийлгэдэг тогтолцоог бий болгох

НЗУХ, ХШҮХ

НЗДТГ

1.

Нийслэлээс иргэн, хуулийн этгээдэд үзүүлж байгаа төрийн үйлчилгээг нэг дор, цогцоор нь, харьяалал харгалзахгүйгээр хүргэх, төрийн үйлчилгээний төвүүдийг нийслэл, дүүрэгт, төрийн үйлчилгээний танхимыг хороодод байгуулж, үйлчилгээний стандарт багцыг бүрдүүлэх;

1.9.1. Төрийн үйлчилгээг шинэ шатанд гаргах, төр иргэндээ үйлчлэх тогтолцоог бүрдүүлэх зорилгоор төрийн үйлчилгээний загвар төвийг нийслэлд, салбар төвүүдийг дүүрэг бүрт байгуулах

НЗДТН, ДЗДТГ ИХАТ

НЗДТГ

1.9.2. Үйлчилгээг иргэдэд ойртуулах, хүртээмжийг сайжруулах зорилгоор хороодын байрны нөхцөлийг сайжруулж, төрийн үйлчилгээний танхимыг тохижуулах

ДЗДТГ ИХАТ Хороод

НЗДТГ

1.9.3. Нийслэлээс үзүүлж байгаа зарим үйлчилгээг дүүрэг, хороонд, Нийслэл, дүүргээс үзүүлж байгаа зарим үйлчилгээг хороонд шилжүүлэх

ИХАТ, Агентлагууд

НЗДТГ

1.9.4. Судалгаанд суурилж төрийн үйлчилгээний шат дамжлагыг цөөлөх, хялбаршуулах ажлыг зохион байгуулах

ИХАТ, ННЗБ-ууд

НЗДТГ

1.9.5. Төрийн үйлчилгээний стандарт багцыг бүрдүүлж, эрх зүйн зохицуулалтыг шинэчлэх

ИХАТ ННЗБ-ууд

НЗДТГ

1.9.6. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчийн цахим ажлын байрууд /out-sourcing/ бий болгох

НЗУХ, НМТГ

НМТГ

1.

Төрийн үйлчилгээний нэгдсэн мэдээллийн систем /платформ/-ыг хөгжүүлэх, цахим үйлчилгээг нэвтрүүлэх;

1.10.1. "Төрийн үйлчилгээг цахимжуулж, техник, эдийн засгийн үндэслэл"-д тулгуурлан төрийн үйлчилгээний нэгдсэн платформыг хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлэх

ИХАТ НЭЗХГ НМТГ

НМТГ

1.10.2. "Иргэд, олон нийтийн портал" /Civil Portal/-ыг хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлэх

ИХАТ НМТГ

Хавсралт

НЗДТГ

1.10.3. "Төрийн үйлчилгээний нэгдсэн мэдээллийн систем"-ийг хөгжүүлэх ажлыг хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлэх

ИХАТ НЭЗХГ НМТГ

НЗДТГ

1.10.4. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд өөр хоорондоо болон иргэдтэй харилцах "Өгөгдөл солилцох дэд бүтэц"-ийг хөгжүүлэх ажлыг хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлэх

ИХАТ НМТГ

НЗДТГ

ЗОРИЛТ ХОЁР. АВЛИГААС АНГИД ТӨРИЙН АЛБАН ХААГЧ

Нийтийн албыг улс төр, эдийн засаг, хувийн ашиг сонирхлын нөлөөллөөс ангид байлгаж, мэргэшсэн албан хаагч болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын ажилтнуудын баталгааг хангаж, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх

1.

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагад улс төрийн томилгоог зогсоох, улс төр эдийн засаг, хувийн ашиг сонирхлын нөлөөллийг бууруулах, мэргэшсэн албан хаагчдаар нийтийн албыг бэхжүүлэх;

2.1.1. Төрийн албаны тухай хууль, Төрийн албаны зөвлөлөөс гаргасан тогтоол шийдвэрүүдийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагааг зохион байгуулах,

Нийслэл дэх Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөл, НЗУХ, ННЗБ-ууд

НЗДТГ

2.1.2. Улс төрийн томилгооноос бусад албан тушаалтны аливаа томилгоог £Мерит зарчимя буюу улс төрийн хуваарилалт, захиалгаар бус, түүнээс бүрэн ангид шударгаар өрсөлдүүлэн шалгаруулах хэлбэрт шилжүүлэх

ННЗБ-ууд

НЗДТГ

2.1.3. Нутгийн захиргааны байгууллагуудын удирдлагыг томилохдоо иргэдээс санал авах, үйл ажиллагааны хөтөлбөрийг нээлттэй хэлэлцүүлэх зарчмаар сонгон шалгаруулж томилох, ажлыг шинэлэг байдлаар зохион байгуулах

Нийслэл дэх Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөл, НЗУХ, ННЗБ-ууд

НЗДТГ

2.1.4. Томилох эрх бүхий албан тушаалтанд "Дохио, сануулга"-ын хуудас гардуулж, анхааруулга өгч байх тогтолцоонд шилжих

ННЗБ-ууд, НЗДТГ

НЗДТГ

2.1.5. Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянаж, дүгнэлгүйгээр албан тушаалд томилсон тохиолдолд томилгоо хийсэн албан тушаалтанд хариуцлага тооцож нийтэд мэдээлж ажиллах

ННЗБ-ууд

НЗДТГ

1.

Албан хаагчийн эрх зүйн болон нийгмийн баталгааг хангаж, тогтвортой ажиллуулах нөхцөлийг бүрдүүлэх;

2.2.1. Албан тушаал эрх мэдлийн сүрээр төрийн байгууллагын дотоод ажил хүний нөөцийн бодлогод ил далд хэлбэрээр нөлөөлж буй зүй бус зохисгүй оролцоо хандлагыг таслан зогсоох чиглэлээр тодорхой ажлыг зохион байгуулах

НЗУХ

НЗДТГ

2.2.2. Албан хаагчийн ажлын бүтээмжид чиглэсэн гүйцэтгэлийн хяналтын горимд шилжүүлэх, хөндлөнгийн оролцоотой эрсдэлийн үнэлгээг хийх, онооны картын системийг нэвтрүүлэх

НЗУХ

НЗДТГ

2.2.3. "Үр дүнд үндэслэсэн урамшууллын журам"-ын төсөл боловсруулж, НИТХ-аар батлуулах, хэрэгжүүлэх

НЗДТГ

НЗДТГ

2.2.4. Албан хаагчтай холбогдуулж гаргасан иргэний гомдлын талаар тайлбар өгөх шаардлагатай тохиолдолд хууль хяналтын байгууллагад шалгуулах, илэрхий үндэслэлгүй тохиолдолд тухайн байгууллага нь албан хаагчийн эрхийг хамгаалах

НЗУХ, ХЭЗХ,

НЗДТГ

2.2.5. Төрийн албан хаагчийг хууль бусаар ажлаас халах, тушаал бууруулах, хууль ёсны эрх ашгийг нь хохироох, нэр төр, алдар хүндийг нь гутаах зорилгоор үндэслэлгүйгээр санаатай гүтгэсэн тогтоогдвол нэр төрийг нь сэргээлгэхээр хамт олон, олон нийтэд мэдээлдэг тогтолцоог бий болгох

ННЗБ-ууд, ХМОНХХ

Хавсралт

НЗДТГ

2.2.6. Албан хаагчдын орон сууцны судалгаанд үндэслэж орон сууц, хашаа байшин худалдан авах, шинээр барих, нөхцөлийг нь сайжруулахад банкны зээлд хамруулах, санхүүгийн дэмжлэг, туслалцаа үзүүлэх

ННЗБ-ууд, НЗУХ

НЗДТГ

1.

Албан хаагчийн ажлын бүтээмжид чиглэсэн гүйцэтгэлийн хяналтын горимд шилжүүлэх, ажлын үр дүнгээр урамшуулах журмыг шинэчлэн мөрдүүлэх;

2.3.1. Сайн засаглалын стандартыг нийтийн албанд нэвтрүүлж, иргэддээ чанартай вйлчилгээ үзвүлдэг мэргэшсэн, тогтвортой, төрийн албан хаагчийг бүх шатанд бэлтгэх

ННЗБ-ууд, НЗУХ

НЗДТГ

2.3.2. Албан хаагчийн ажлын бүтээмжид чиглэсэн гүйцэтгэлийн хяналтын горимд шилжүүлэх, хөндлөнгийн оролцоотой эрсдэлийн үнэлгээг хийх, онооны картын системийг нэвтрүүлэх

НЗУХ

НЗДТГ

2.3.3. "Үр дүнд үндэслэсэн урамшууллын журам"-ын төсөл боловсруулж, батлуулах

НЗУХ

НЗДТГ

1.

Албан хаагчийн сэтгэлгээ хандлагыг өөрчлөх, мэргэшүүлэх

2.4.1. Удирдах албан тушаалтны "Ёс зүйн мэдэгдэл", Тангараг"-ийн төсөл боловсруулах, журам гаргах

НЗДТГ

НЗДТГ

2.4.2. ННЗБ-ын удирдах албан тушаалд томилогдож байгаа албан тушаалтан нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл /радио, телевиз, сонин, цахим хуудас/-ээр Ёс зүйн мэдэгдэл гаргаж иргэдийн өмнө хариуцлага хүлээдэг тогтолцоонд шилжүүлэх

НЗУХ, ХМОНХХ

НЗДТГ

2.4.3. Албан хаагчийг чадавхижуулах, сургалтад хамруулах ажлыг шат дараатай зохион байгуулах

НЗУХ

НЗДТГ

1.

Ажлын байран дахь ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдлийг бууруулах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх;

2.5.1. "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан тушаалтнуудын иргэдтэй хийх уулзалтад ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай журам" -ын хэрэгжилтийг хангуулах

ННЗБ-ууд

НЗДТГ

2.5.2. Ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэл бүхий албан тушаалын жагсаалтыг тогтмол гаргах

ННЗБ-ууд, НЗДТГ

НЗДТГ

2.5.3. Үнэлгээний хороо, ажлын хэсэг, уралдаант шалгаруулалтад орж байгаа албан хаагчдын "Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл"ийг гаргуулж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах

НЗУХ

НЗДТГ

2.5.4. Захиргааны акт гаргах, удирдах, хяналт шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө тус бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргаж хэвших

НЗУХ

НЗДТГ

ЗОРИЛТ ГУРАВ.ТУНГАЛАГ САНХҮҮТЭЙ УЛААНБААТАР

Нийслэл, дүүргийн нутгийн захиргааны байгууллага, өмчит үйлдвэрийн газар, компаниудын төсвийн зарцуулалт, худалдан авах ажиллагаа болон зөвшөөрөл олголтыг олон нийтэд ил тод нээлттэй, хяналттай болгох

1.

Төсвийн орлого, зарлага болон өр, зээл, өмч, хөрөнгийн зарцуулалттай холбоотой аливаа мэдээллийг олон

Хавсралт

нийтэд ил тод, нээлттэй, хяналттай болгох, нийслэл, дүүргийн нутгийн захиргааны байгууллага, өмчит үйлдвэрийн газар, компаниудыг "Шилэн данс"-ны тогтолцоонд шилжүүлэх;

3.1.1. "Шилэн дансны тухай" хуулийг хэрэгжүүлэх, хяналт тавих ажлыг зохион байгуулах

ННЗБ-ууд, СТСХ

НЗДТГ

3.1.2. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын төсөв санхүү, орлого, зарлага, өр, зээл болон өмч, хөрөнгийн зарцуулалттай холбоотой мэдээллийг олон нийтэд ил тод сурталчлан сайтад нээлттэй байршуулж, хяналттай болгон "Шилэн данс"-ны тогтолцоонд шилжүүлэх

НМТГ, СТСХ, Нийслэл дүүргийн Дотоод аудитын алба

НЗДТГ

3.1.3. Орон нутгийн хөгжлийн сангийн ил тод байдлыг хангах, иргэдийн зөвлөлөөр хянуулах

ДЗДТГ

НЗДТГ, СТСХ

1.

Төсвийн төлөвлөлтийн үр ашигтай байдал, гүйцэтгэлийн хэмнэлт, зарцуулалт дахь хөндлөнгийн хяналт, оролцоог нэмэгдүүлж, дотоод аудитын хяналтыг боловсронгуй болгох;

3.2.1. Дотоод аудитын хяналтыг тогтолцоог боловсронгуй болгох

Нийслэл, дүүргийн Дотоод аудит

НЗДТГ

3.2.2. Төсвийн зарцуулалт хэмнэлтийн талаар тусгай вэб хуудастай болох /цахим хуудсандаа £байгууллагын төсөв" гэсэн цэс суулгах/

ННЗБ-ууд, НМТГ

НЗДТГ

1.

Хувийн хэвшлийн байгууллагын хөрөнгө оруулалтаар гүйцэтгэх боломжтой ажил үйлчилгээг төрийн байгууллага хэрэгжүүлэхийг хязгаарлах;

3.3.1. Хувийн хэвшлийн байгууллагын хөрөнгө оруулалтаар гүйцэтгэх боломжтой ажил үйлчилгээний жагсаалт гаргах, иргэдийн танхимаар хэлэлцүүлэх, нийтэд мэдээлэх

СБТХ, ХМОНХХ

НЗДТГ

3.3.2. Хувийн хэвшлийн байгууллагын хөрөнгө оруулалтаар гүйцэтгэх боломжтой ажил үйлчилгээнд төсвийн хөрөнгө оруулалт хийхийг хязгаарласан журам гаргаж хэрэгжүүлэх замаар бизнес дэх төрийн оролцоог багасгах

СБТХ

НЗДТГ

3.3.4. Бизнес, эдийн засгийн харилцааг зохицуулахад нэн шаардлагатай байгаа дүрэм, журмуудыг шинэчлэн гаргах

СБТХ, СТСХ

НЗДТГ

1.

Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох журмыг хялбарчлах £Шилэн лиценз" системийг ашиглах;

3.4.1. Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг цахимжуулах, "Шилэн лиценз" системийг хөгжүүлэн иргэд хүлээн авах төвөөр дамжуулан зохион байгуулах

ЗАА, БОНХГ, НЭМГ, НБГ, ИХАТ

НЗДТГ

3.4.2. Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох журмыг хялбарчилж, бодлого, үйл ажиллагааг ил тод нээлттэй болгох, сайтад ил тод байршуулах

ЗАА, БОНХГ, НЭМГ, НБГ, НМТГ

НЗДТГ

3.4.3. Тусгай зөвшөөрөл, лицензээр олгодог зарим үйлчилгээ, үйл ажиллагааг хувийн хэвшил, төрийн бус байгууллагуудын оролцоотойгоор хэрэгжүүлэх нөхцөл бололцоог бүрдүүлэх

НЗУХ, ХЭЗХ

НЗДТГ

3.4.4. Барилга барихад зайлшгүй шаардлагатай зөвшөөрлүүдийг нэгтгэн нэг цэгийн үйлчилгээнд шилжүүлж, төрийн байгууллагуудын ажил үүргийн давхардлыг арилгах

ИХАТ, ЗАА, НЕТГ

НЗДТГ

Хавсралт

1.

Нутгийн захиргааны байгууллагуудын худалдан авах ажиллагааг зөвхөн тухайн салбарт мэргэшсэн мэргэжлийн байгууллага зохион байгуулах механизмыг бүрдүүлэх, цахим хэлбэрт оруулж £Шилэн тендерийн тогтолцоонд шилжүүлэх;

3.5.1. £Худалдан авах үйл ажиллагааг цахимжуулж, зарлагдсан тендерийг сайтад тогтмол байршуулан £Шилэн тендерийн тогтолцоонд шилжүүлэх

НХААГ, НМТГ

НЗДТГ

3.5.2. "Ухаалаг тендер систем байгуулах, нэвтрүүлэх

НМТГ

НМТГ

1.

Худалдан авах ажиллагаан дахь нууцлалыг сайжруулах, хариуцлагыг өндөржүүлэх, хар жагсаалтад байгаа хуулийн этгээдийн цахим сонгон шалгаруулалтад оролцох боломжийг хязгаарлах;

3.6.1. Нийслэлийн захиалгаар төсөл хөтөлбөрт шалгарч гэрээний үүргээ биелүүлээгүй байгууллагын хар жагсаалтыг гаргаж, нийтэд мэдээлэх, дахин оролцох боломжийг хязгаарлах

ХААГ

НЗДТГ

3.6.2. Худалдан авах ажиллагаан дахь нууцлалыг сайжруулах, хариуцлагыг өндөржүүлэх

ХААГ

НЗДТГ

1.

Худалдан авах үйл ажиллагааг £Видео тендер болон бусад хэлбэрээр зохион байгуулж, тендерийн ил тод байдлыг сурталчлах;

3.7.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг улиралд нэг удаа £Видео тендер хэлбэрээр зохион байгуулах

ХААГ

НЗДТГ

3.7.2. £Видео тендер зохион байгуулахтай холбоотой сурталчилгааг мэдээллийн бүх хэрэгслийг ашиглан иргэд, олон нийтэд түгээх ажлыг үе шаттай зохион байгуулах

ХААГ

НЗДТГ

1.

Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын үйл ажиллагааг төслийн менежментийн зарчимд шилжүүлж, удирдлага, санхүүгийн үйл ажиллагааг ил тод болгох;

3.8.1. Нийслэлд Хөгжлийн корпарацы байгуулах

ННЗБ-ууд

НЗДТГ

3.8.2. Төсөл хөтөлбөртэй холбоотой зардлын тайланг олон нийтэд мэдээлэх, мэдээлэл авах боломжоор хангах

ННЗБ-ууд

НЗДТГ

1.

Нийслэл, дүүргийн сонгуулийн хороод, нам, эвслийн сонгуулийн зардлын тайланг нийтэд мэдээлэх;

3.9.1. Орон нутгийн сонгуульд нэр дэвшигч нам эвсэл, нэр дэвшигчдийн авсан хандивыг нийтэд мэдээлэх

Нийслэл, дүүргийн сонгуулийн хороо

Нийслэл, дүүргийн ИТХ

3.9.2. Орон нутгийн сонгуулийн үеэр сонгуулийн зардлын тайланг мэдээлдэг байх

Нийслэл, дүүргийн сонгуулийн хороо

Нийслэл, дүүргийн ИТХ

ЗОРИЛТ ДӨРӨВ. НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ИЛ ТОД, ҮР АШИГТАЙ ТОГТОЛЦОО

Нийслэлийн өмчийг удирдлага, бүртгэл, хяналт, үнэлгээний нэгдсэн, ил тод тогтолцоотой болгох, хөрөнгийн үр ашгийг нэмэгдүүлэх, зарим өмчийг хувьчлах, төрийн аж ахуйн үйл ажиллагааг хязгаарлах

1.

Нийслэлийн өмчийн бүртгэл хяналт, үнэлгээний нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх, үйл ажиллагааны үр дүнг тооцох механизмыг сайжруулж, хариуцлагыг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг ил тод болгох;

Хавсралт

4.1.1. Нийслэлийн өмчийн бүртгэл хяналт, үнэлгээний нэгдсэн тогтолцоог боловсронгуй болгох

НӨХГ

НЗДТГ

4.1.2. Нийслэлийн өмчит үйлдвэрийн газруудын үйл ажиллагаа, санхүүгийн байдалд дүн шинжилгээ хийж үр ашиг, менежментийг сайжруулах

НӨХГ

НЗДТГ

4.1.3. Нийслэлийн өмчийн элэгдэл хорогдлыг тооцож, цаашид ашиглалтгүй болсон өмчийг худалдах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах

НӨХГ

НЗДТГ

1.

Нийслэлийн өмчит үйлдвэрийн газар нэмж байгуулахыг хязгаарлах;

4.2.1. Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын үйл ажиллагаа, чиг үүрэгт судалгаа хийх

НЗДТГ, НӨХГ

НЗДТГ

4.2.2. Үйл ажиллагаа, чиг үүрэг нь давхардсан төсөвт үйлдвэрийн газар нэмж байгуулахгүйгээр Нийслэлийн өмчит үйлдвэрийн газруудад оновчтой зохион байгуулалт хийж ажиллах

НӨХГ

НЗДТГ

1.

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын чиг үүргийг төрөлжүүлж, бүтэц зохион байгуулалтыг оновчтой болгох;

4.3.1. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын аж ахуйн үйл ажиллагааны оролцоог багасгахтай холбоотойгоор нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын чиг үүргийг "Захиргаа", Хот нийтийн аж ахуй", "Хөгжлийн корпораци" гэсэн чиглэлүүдэд хувааж, бүтцэд өөрчлөлт оруулах

НЗДТГ, НЗУХ, ХЭЗХ

НЗДТГ

1.

Нийслэлд зайлшгүй шаардлагатай байгаагаас бусад нийслэлийн өмчит үйлдвэрийн газар, нийслэлийн өмчийг хувьчлах;

4.4.2. Тухайн жилд хувьчлах өмчийн судалгааг гарган холбогдох газруудад танилцуулан шийдвэр гаргуулж хувьчлах ажлыг зохих хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах

НӨХГ

НЗДТГ

4.4.3. Хувьчлагдах ААНБ, барилга байгууламжийн худалдах доод үнийг тогтоох зорилгоор бизнесийн болон хөрөнгийн үнэлгээ хийлгэх зар мэдээ гаргах, шалгаруулалтыг ил тод хэлбэрээр хийж гэрээ байгуулах, үнэлгээний тайланг хүлээн авах

НӨХГ

НЗДТГ

1.

Газрын бирж байгуулах, газрын мэдээллийн нэгдсэн сантай болох

4.5.1. Газрын бирж байгуулах

НӨХГ

НЗДТГ

4.5.2. Газрын мэдээллийн нэгдсэн санг бий болгох, газар өмчлөл, эзэмшил, газрын худалдааны талаарх мэдээллийг онлайн болох

НӨХГ

НЗДТГ

ЗОРИЛТ ТАВ. ДҮРЭМТЭЙ ХОТ

Хотын амьдралын олон талт асуудлыг зохицуулсан £Дүрэмтэй хот^а хөтөлбөрийг хэрэгжүүлэх

1.

Нийслэл дэх хотуудыг иргэддээ нээлттэй байх, иргэдийн оролцоотой асуудлаа шийддэг байхад чиглэсэн дүрэмтэй болгох, хотын Үндсэн дүрмийг хотын оршин суугчдын санал асуулгаар батлах;

5.1.1. Хотын үндсэн дүрмийн төслийг цахим хуудсаар болон бусад хэлбэрээр танилцуулж, хэлэлцүүлэх

ХЭЗХ

НЗДТГ

Хавсралт

5.1.2. Налайх, Багануур дүүрэгт дараах асуудлаар бүх нийтийн санал асуулга явуулах

ХЭЗХ

НЗДТГ

5.1.3. Улаанбаатар хотын Ерөнхий төлөвлөгөөний дагуу нийслэлийн нутаг дэвсгэрийн тэнцвэрт хөгжлийг хангах, Улаанбаатар хотын хэт төвлөрлийг сааруулах зорилтын хүрээнд нийслэл дэх бусад хотууд өөрийн онцлогоо тусган батлах боломжтой Үндсэн дүрмийн загварыг боловсруулж, санал болгох

ХЭЗХ

НЗДТГ

1.

Хотын удирдлага, хотод оршин суугч бүр нэг л дүрэм журмын хүрээнд харилцах нөхцөлийг бүрдүүлж, хотын амьдралын асуудлаар гарах аливаа шийдвэр зөвхөн олонхийн эрх ашигт нийцэж байх тогтолцоог бий болгох;

5.2.1. Хотын Үндсэн дүрмийн үзэл баримтлалд нийцсэн хотын салбар дүрмийн төслийг иргэд, олон нийтэд танилцуулж, хэлэлцүүлэх, батлуулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулах

ХЭЗХ

НЗДТГ

5.2.2. Хотын эдийн засаг, нийгмийн амьдрал, аж ахуйн үйл ажиллагааны хотын стандартыг дүрмээр тогтоож, мөрдүүлэх

ХЭЗХ, ННЗБ-ууд

НЗДТГ

ЗОРИЛТ ЗУРГАА. АВЛИГЫГ ҮЛ ТЭВЧИГЧ ХОТЫН ИРГЭД

Авлигын эсрэг ил тод улаанбаатар академийг байгуулж, иргэд, олон нийтийн авлигын талаарх боловсролыг нэмэгдүүлж, соён гэгээрүүлэх ажлыг өргөнөөр зохион байгуулах

1.

Авлигын талаар нийслэлийн иргэдэд мэдээлэл өгч, соён гэгээрүүлж, тэдний оролцоог хангах тогтвортой институци болох "Авлигын эсрэг ил тод Улаанбаатар академи"-ийг байгуулах;

6.1.1. Академийн дүрэм боловсруулах, "Авлигын эсрэг ил тод Улаанбаатар академи"-ийг байгуулах, бүс нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулах

НЗДТГ, НЗУХ, ХЭЗХ

НЗДТГ

6.1.2. Авлигын эсрэг ил тод Улаанбаатар академи, олон нийтийн зөвлөл, иргэний зөвлөлийн үйл ажиллагааг уялдуулж ажлын чиг үүргийг тодорхой болгох

НЗДТГ

НЗДТГ

1.

Олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх, авлигын эсрэг туршлагаас судлах, шинжээчдийг урьж ажиллуулах, тэдгээрийн зөвлөмжийг хэрэгжүүлэх;

6.2.1. Олон улсын түвшинд авлигын эсрэг туршлага хуримтлуулсан гадаадын улс орны туршлага амжилтыг судлах, хамтын ажиллагаа өрнүүлэх

НЗУХ, ГХХАХ

НЗДТГ

6.2.2. Гадаадын судлаач, шинжээчдийг Улаанбаатар хотод урьж ажиллуулах, сургалт, семинар зохион байгуулах

НЗУХ, ГХХАХ

НЗДТГ

1.

Авлигыг үл тэвчих ухамсрыг иргэдэд төлөвшүүлэх нөхцөлийг бүрдүүлэх бүхий л үйл ажиллагааг дэмжих;

6.3.1. Авлигын эсрэг хэлэлцүүлгийг ТББ, иргэдийн дунд улирал тутам зохион байгуулж шилдэг санал санаачилгыг хэрэгжүүлж ажиллах

НЗУХ

НЗДТГ

6.3.2. Шийдвэр гаргахад шаардлагатай мэдээлэл авах, санал сонсох, олон нийтийн оролцоог хангах үүднээс "Нийтийн сонсголыг" зохион байгуулж хэвшүүлэх

НЗДТГ

НЗДТГ

1.

Авлига, хууль бус үйлдлийн талаар мэдээлсэн албан тушаалтан, иргэнийг урамшуулах, шүгэлдэгчийг

Хавсралт

хамгаалахтай холбоотой эрх зүйн орчинг бүрдүүлэхэд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах;

6.4.1. "Шүгэлдэгч"-ийг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг бий болгоход оролцох, санал өгөх

ХЭЗХ

НЗДТГ

6.4.2. Олон улсын байгууллагатай хамтран шүгэлдэгчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр ажиллах

ХЭЗХ, ГХХАХ

НЗДТГ

6.4.3. Авлига, хууль бус үйлдлийн талаар үнэн зөв мэдээлэл өгсөн иргэнийг урамшуулж, амь нас, эрүүл мэнд, үр хүүхдийг нь хамгаалах талаар журам боловсруулж хэрэгжүүлэх

НЗУХ, ХЭЗХ

НЗДТГ

ЗОРИЛТ ДОЛОО. ИРГЭН, ИРГЭНИЙ НИЙГМИЙН ОРОЛЦОО

Нийслэлийн бүх шатны байгууллагын нийтийн эрх ашгийг хөндсөн аливаа асуудлаар шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэд, иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангах, авлигын болон эрсдлийн хөндлөнгийн үнэлгээ хийдэг тогтолцоонд шилжих

1.

Нийслэлийн бүх шатны байгууллага нийтээр дагаж мөрдөх, нийтийн эрх ашгийг хөндсөн шийдвэр гаргах, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, үнэлэхэд иргэд, иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангах;

7.1.1. Нийслэлд ил тод байдлыг нэмэгдүүлэх, албан тушаалтны хариуцлагыг дээшлүүлэх, авлигыг бууруулах чиглэлээр Нийслэлийн ЗДТГ-тай хамтран ажиллах авлигын эсрэг "Нийслэлийн иргэний зөвлөл" /НИЗ/ байгуулах

НЗДТГ, ТББ

НЗДТГ

7.1.2. Захиргааны зөрчлийг илрүүлэхэд иргэд болон иргэний нийгмийн байгууллагын оролцоотой бүртгэх тогтолцоог бий болгох

ХЭЗХ, ННЗБ-ууд

НЗДТГ

7.1.3. Бодлого төсөв боловсруулах, үнэлгээ өгөх, үйл ажиллагааны хяналт хийх нөхцөл бололцоогоор иргэний нийгмийн төлөөллийн оролцоог хангахад тусгайлан зохицуулсан журам боловсруулах

НЗДТГ, ННЗБ-ууд

НЗДТГ

1.

Нийслэлийн бүх шатны байгууллага £Нийтийн зар мэдээ-г хүргэдэг болох;

7.2.1. Иргэдэд чиглэсэн зар мэдээг мэдээлийн арга хэрэгслийг бүрэн ашиглаж хүргэх

ИХАТ НМТГ

НЗДТГ

7.2.2. Байгууллагын өргөдөл гомдлын программыг боловсронгуй болгох, мэдээлэл шинэчлэгдэх боломжийг нэмэгдүүлэх

ИХАТ НМТГ

НЗДТГ

7.2.3. Нийслэлийн нутгийн захиргааны албан хаагчийг албаны цахим шуудан ашиглах боломжийг бүрдүүлэх

ИХАТ НМТГ

НЗДТГ

1.

£Иргэдийн санаачилгын хороо-г хөхиүлэн дэмжих;

7.3.1. Авлигатай тэмцэх газрын Соён гэгээрүүлэх хэлтэс болон холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах,

НЗУХ, ХЭЗХ

НЗДТГ

7.3.2. Жил бүр "Авлигын эсрэг Нийслэлийн хөтөлбөр"-ийн хүрээнд оюутан сурагчдын дунд илтгэл, эссэ бичгийн уралдаан зарлан хэлэлцүүлэх, дүгнэх, олны хүртээл болгох ажлыг зохион байгуулах

НЗУХ, ХЭЗХ

НЗДТГ

Хавсралт